| D01 | 2025 оны 01-р сарын 31-нээрх үлдэгдэл      | 221,624,669.45                  | 425,791,452.47        | 1,009,941,809.11  | 0.00  | 1,560,272,520.85                        |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл                 | 221,624,669.45                  | 428,410,781.47        | 910,237,069.93    | 0.00  | 1,560,272,520.85                        |
| D08 | Тайлант үеийн үр дүн                       |                                 |                       | 278,193,055.62    |       | 278,193,055.62                          |
| D09 | 2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл      | 221,624,669.45                  | 428,410,781.47        | 1,188,430,125.55  | 0.00  | 1,838,465,576.47                        |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/ төгрөгөөр /

| Үзүүлэлт  | Тайлант оны             |                         |                      |              |
|---|-------------------------|-------------------------|----------------------|--------------|
|   | Төлөвлөгөө              | Гүйцэтгэл               | Зөрүү                | Хувь         |
| <b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b> | <b>1,786,556,100.00</b> | <b>1,713,682,061.27</b> | <b>72,874,038.73</b> | <b>95.92</b> |
| Татварын бус орлого                                 | 1,786,556,100.00        | 1,713,682,061.27        | 72,874,038.73        | 95.92        |
| <b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>                      | <b>1,769,241,100.00</b> | <b>1,698,651,161.27</b> | <b>70,589,938.73</b> | <b>96.01</b> |
| Улсын төсвөөс санхүүжих                             | 1,769,241,100.00        | 1,698,651,161.27        | 70,589,938.73        | 96.01        |
| <b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>        | <b>17,315,000.00</b>    | <b>15,030,900.00</b>    | <b>2,284,100.00</b>  | <b>86.81</b> |
| Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих           | 17,315,000.00           | 15,030,900.00           | 2,284,100.00         | 86.81        |
| <b>Ажиллагчидтай холбогдсон зардал</b>              | <b>1,484,373,200.00</b> | <b>1,436,450,370.63</b> | <b>47,922,829.37</b> | <b>96.77</b> |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил                   | 1,455,486,400.00        | 1,408,304,428.66        | 47,181,971.34        | 96.76        |

**Баянхонгор аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

|  |                       |                       |                      |               |
|--|-----------------------|-----------------------|----------------------|---------------|
| Үндсэн цалин   | 829,386,400.00        | 791,119,803.25        | 38,266,596.75        | 95.39         |
| Нэмэгдэл   | 526,100,000.00        | 435,379,647.95        | 90,720,352.05        | 82.76         |
| Унаа хоолны хөнгөлөлт  | 100,000,000.00        | 81,989,727.46         | 18,010,272.54        | 81.99         |
| Урамшуулал   | -                     | 99,815,250.00         | (99,815,250.00)      |               |
| <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>                | <b>28,886,800.00</b>  | <b>28,145,941.97</b>  | <b>740,858.03</b>    | <b>97.44</b>  |
| Эрүүл мэндийн даатгал  | 28,886,800.00         | 28,145,941.97         | 740,858.03           | 97.44         |
| <b>Бараа ,үйлчилгээний урсгал зардал</b>                             | <b>303,587,700.00</b> | <b>276,901,690.64</b> | <b>26,686,009.36</b> | <b>91.21</b>  |
| <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>                     | <b>153,128,800.00</b> | <b>145,463,976.39</b> | <b>7,664,823.61</b>  | <b>94.99</b>  |
| Гэрэл, цахилгаан   | 23,491,500.00         | 21,496,080.49         | 1,995,419.51         | 91.51         |
| Түлш, халаалт  | 116,541,500.00        | 111,226,599.90        | 5,314,900.10         | 95.44         |
| Цэвэр, бохир ус  | 13,095,800.00         | 12,741,296.00         | 354,504.00           | 97.29         |
| <b>Хангамж, бараа материалын зардал</b>                              | <b>41,834,100.00</b>  | <b>34,427,431.25</b>  | <b>7,406,668.75</b>  | <b>82.30</b>  |
| Бичиг хэрэг  | 5,526,300.00          | 4,003,350.00          | 1,522,950.00         | 72.44         |
| Тээвэр, шатахуун   | 30,300,400.00         | 25,182,000.00         | 5,118,400.00         | 83.11         |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр                                   | 2,493,700.00          | 2,214,081.25          | 279,618.75           | 88.79         |
| Ном, хэвлэл  | 1,399,100.00          | 1,200,000.00          | 199,100.00           | 85.77         |
| Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал            | 2,114,600.00          | 1,828,000.00          | 286,600.00           | 86.45         |
| <b>Нормативт зардал</b>  | <b>77,294,000.00</b>  | <b>70,741,500.00</b>  | <b>6,552,500.00</b>  | <b>91.52</b>  |
| Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл                                      | 1,995,600.00          | 1,840,000.00          | 155,600.00           | 92.20         |
| Хоол, хүнс   | 75,298,400.00         | 68,901,500.00         | 6,396,900.00         | 91.50         |
| <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>                             | <b>24,404,000.00</b>  | <b>20,510,430.00</b>  | <b>3,893,570.00</b>  | <b>84.05</b>  |
| Багаж, техник, хэрэгсэл  | 7,554,400.00          | 5,860,900.00          | 1,693,500.00         | 77.58         |
| Урсгал засвар  | 16,849,600.00         | 14,649,530.00         | 2,200,070.00         | 86.94         |
| <b>Томилолт, зочны зардал</b>  | <b>299,500.00</b>     | <b>200,000.00</b>     | <b>99,500.00</b>     | <b>66.78</b>  |
| Дотоод албан томилолт  | 299,500.00            | 200,000.00            | 99,500.00            | 66.78         |
| <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>      | <b>6,487,300.00</b>   | <b>5,418,353.00</b>   | <b>1,068,947.00</b>  | <b>83.52</b>  |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,998,400.00          | 1,932,800.00          | 65,600.00            | 96.72         |
| Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох                             | 298,600.00            | -                     | 298,600.00           | -             |
| Тээврийн хэрэгслийн татвар   | 1,246,700.00          | 746,348.00            | 500,352.00           | 59.87         |
| Тээврийн хэрэгслийн оношлогоо  | 132,000.00            | 132,000.00            | -                    | 100.00        |
| Мэдээлэл, технологийн үйлчилгээ                                      | 1,270,500.00          | 1,148,500.00          | 122,000.00           | 90.40         |
| Газрын төлбөр  | 1,541,100.00          | 1,458,705.00          | 82,395.00            | 94.65         |
| <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                               | <b>140,000.00</b>     | <b>140,000.00</b>     | <b>-</b>             | <b>100.00</b> |

**Баянхонгор аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

|  |                         |                         |                      |               |
|--|-------------------------|-------------------------|----------------------|---------------|
| Бараа үйлчилгээний бусад зардал          | 140,000.00              | 140,000.00              | -                    | 100.00        |
| <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>                  | <b>330,000.00</b>       | <b>330,000.00</b>       | -                    | 100.00        |
| <b>Бусад урсгал шилжүүлэг</b>            | 330,000.00              | 330,000.00              | -                    | 100.00        |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал  | 330,000.00              | 330,000.00              | -                    | 100.00        |
| <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>                     | <b>330,000.00</b>       | <b>330,000.00</b>       | -                    | <b>100.00</b> |
| <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>   | <b>1,787,960,900.00</b> | <b>1,713,352,061.27</b> | <b>74,608,838.73</b> | <b>95.83</b>  |
| <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b> | <b>1,788,290,900.00</b> | <b>1,713,682,061.27</b> | <b>74,608,838.73</b> | <b>95.83</b>  |

**2.5 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/ төгрөгөөр /

| Дансны код  | Үзүүлэлт  | Гүйцэтгэл            |
|-------------|---|----------------------|
| <b>I</b>    | <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>  | <b>42,600,000.00</b> |
| <b>21</b>   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>  | <b>42,600,000.00</b> |
| <b>210</b>  | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>  | <b>42,600,000.00</b> |
| <b>2104</b> | <b>Хангамж, бараа материалын зардал</b>   | <b>2,500,000.00</b>  |
| 210402      | Тээвэр, шатахуун  | 2,500,000.00         |
| <b>2106</b> | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>  | <b>16,600,000.00</b> |
| 210604      | Урсгал засвар   | 16,600,000.00        |
| <b>2108</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>   | <b>8,500,000.00</b>  |
| 210801      | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж  | 8,500,000.00         |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>  | <b>15,000,000.00</b> |
| 210902      | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх   | 15,000,000.00        |
| <b>II</b>   | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>   | <b>42,600,000.00</b> |
| <b>1311</b> | <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>  | <b>42,600,000.00</b> |
| 131103      | ЗГНХ,ЗДНХерөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 32,600,000.00        |
| 131104      | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө  | 10,000,000.00        |

**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

**3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Баянхонгор аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь шүүхийн шийдвэрийг нэг мөр гүйцэтгэх, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дэлхий нийтээр мөрдөж байгаа эрх зүйн хэм хэмжээнд нийцүүлж, олон улсын жишигт хүргэх эрхэм зорилгынхоо хүрээнд үйл ажиллагааныхаа зорилтыг тодорхойлжээ.

Тус газар нь Шүүхийн шийдвэрийн гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2017 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн Б/1085 дугаар тушаалаар анх 32 орон тоотой бүтэц, орон тоо болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар болгосон байна.

Мөн ШШГЕГ-ын даргын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн А/27 дугаар тушаалаар Баянхонгор аймаг дахь ШШГГ-т орон тооны хуваарилалтаар 2 шийдвэр гүйцэтгэгчийн албан тушаалыг нэмж нийт 37 алба хаагчтай үйл ажиллагаа явуулсан байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын дотоод хяналтыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Шалгалт, үнэлгээ, дотоод аудитын газар хариуцан хэрэгжүүлдэг бөгөөд таван жилд нэг удаа газар дээрх хяналт, шалгалтыг хийдэг байна.

Тайлант онд тус газраас байгууллагад хяналт, шалгалт хийгдээгүй тул дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах зорилгоор дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймаг дахь ШШГГ- нь 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймаг дахь ШШГГ- нь 2025 оны санхүүгийн тайланг Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 279,768.1 мянган төгрөг буюу 17.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| <i>/мянган төгрөгөөр/</i> |                |                 |           |
|---------------------------|----------------|-----------------|-----------|
| Үзүүлэлт                  | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт  |
| Б                         | 1              | 2               | 3=2-1     |
| Мөнгөн хөрөнгө            | 5,594.1        | 446.0           | (5,148.1) |

**Баянхонгор аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

|  |                    |                    |                  |
|--|--------------------|--------------------|------------------|
| Авлага                                       | -                  | -                  | -                |
| Бараа материал                               | 41,906.0           | 88,551.7           | 46,645.7         |
| Үндсэн хөрөнгө                               | 2,087,121.6        | 2,275,105.2        | 187,983.7        |
| Хуримтлагдсан элэгдэл                        | (573,690.1)        | (523,403.2)        | 50,286.9         |
| <b>Нийт хөрөнгө</b>                          | <b>1,560,931.6</b> | <b>1,840,699.7</b> | <b>279,768.1</b> |
| Өр төлбөр                                    | 659.1              | 2,234.2            | 1,575.1          |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/     | 1,560,272.5        | 1,838,465.6        | 278,193.1        |
| <b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b> | <b>1,560,931.6</b> | <b>1,840,699.7</b> | <b>279,768.1</b> |

*Эх сурвалж: Байгууллагын 2025 оны санхүүгийн тайлан*

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 446.0 мянган төгрөг байгаа нь хүмүүжигч нарын нэрийн дансны үлдэгдэл байна.

Өмнөх оны мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нь хүмүүжигч нарын нэрийн данс болон ахмадын сангийн дансны үлдэгдэл нийт 5,594.1 мянган төгрөг байсан бөгөөд тайлант онд 5,148.1 мянган төгрөгөөр буурсан нь ахмадын сангийн үлдэгдлийн зарцуулсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл тайлант оны эцэст 88,551.7 мянган төгрөг болж, өмнөх үеэс 46,645.7 мянган төгрөгөөр өссөн байна. Төсвийн хөрөнгөөр 133,139.0 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч, 48,042.0 мянган төгрөгийн хөрөнгийг ШШГЕГ болон Баянхонгор сумын ИТХ-ын даргын 2025 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 36 дугаар захирамжаар үнэ төлбөргүй шилжүүлэн авч нийт 134,535.3 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж нягтлан бодох бүргэлд бүртгэсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,275,105.2 мянган төгрөг болж 187,983.7 мянган төгрөгөөр өссөн байна. Тайлант онд ТӨБЗГ-ын 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 824 тогтоолоор 279,000.0 мянган төгрөгийн өртөг бүхий Ниссан патрол Y62 маркийн тээврийн хэрэгсэл, ШШГЕГ-аас хуваарилсан 25,153.9 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж үнэ төлбөргүй хүлээн авч, төсвийн хөрөнгөөр 5,179.4 мянган төгрөгийн хөрөнгийг худалдан авч нийт 309,333.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг орлогод авсан нь хөрөнгийн өсөлтөд нөлөөлсөн байна. Харин ТӨБЗГ-ын 2024 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 489 дүгээр тогтоолоор ашиглалтын хугацаа дууссан, үлдэх өртөггүй 115,513.3 мянга төгрөгийн хөрөнгийг акталсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 2,234.2 мянган төгрөг болж өмнөх оноос 1,575.1 мянган төгрөгөөр өссөн байна. Тайлант онд төсвийн эрх нээгдээгүйгээс бусад зардлын (бичиг хэрэг) өр 1,663.2 мянган төгрөгийн өр шинээр үүссэн нь өр төлбөр данс өсөхөд голлох нөлөө үзүүлсэн байна. Харин хүмүүжигч нарын нэрийн дансны үлдэгдэл 446.0 мянган төгрөгийг өглөгөөр бүртгэсэн ба тайлант онд 213.1 мянган төгрөгөөр буурсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,838,465.6 мянган төгрөг болж 278,193.1 мянган төгрөгөөр өссөн нь өмнөх оны үр дүн 278,193.1 мянган төгрөгтэй холбоотой байна.

Тус байгууллага нь “Ординат” ХХК -ны санхүүгийн тайлангийн UNICUS санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх хөтлөх шийдвэр гүйцэтгэлийн, төсвийн төсөл боловсруулах төлөвлөлтийн онлайн программыг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Анхны гэрээний үнээр байгууллагын биет бус хөрөнгөнд бүртгэлтэй бөгөөд тайлант онд нийт 554.5 мянган төгрөгийн хөгжүүлэлттэй холбоотой зардал гарсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,506,675.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,506,675.0 мянган төгрөгөөр тооцон дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн. Дээд шатны төсвийн захирагчаас төсвийн төслийг 4,459.0 мянган төгрөгөөр бууруулж, 1,502,216.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант онд төсвийн хуваарьт хоёр удаагийн тодотгол хийж, анхны батлагдсан төсөв 286,074.9 мянган төгрөгөөр нэмэгдэн нийт 1,788,290.9 мянган төгрөгийн төсөв батлагдсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Баянхонгор аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь улсын төсвийн санхүүжилт 1,698,651,2 мянга, туслах үйл ажиллагаанаас 15,030.9 мянга, нийт 1,713,682.1 төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,711,308.5 мянган төгрөгийг зарцуулж улсын төсөвт 2,373.5 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,713,682.1 мянган төгрөг буюу 95.8 хувьтай байна.

Цалин болон нэмэгдэл урамшууллын зардлаас 47,181.9 мянга, ажил олгогчийн НДШ-ийн зардлаас 11,489.9 мянга, бараа ,үйлчилгээний урсгал зардал зардалаас 26,686.0 мянган төгрөгийг тус тус зарцуулаагүй нь зардлын гүйцэтгэл бүрэн биелэхгүй үлдэхэд голлон нөлөөлсөн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ                        | Төлөвлөгөө  | Гүйцэтгэл   | /мянган төгрөгөөр/ |         |
|-----|--|-------------|-------------|--------------------|---------|
|     |  |             |             | Зөрүү              | Биелэлт |
| 1   | 80101 Үндсэн үйл ажиллагааны зардал          | 1,767,250.4 | 1,695,124.4 | 72,126.0           | 95.9    |
| 2   | 80102 Туслах үйл ажиллагааны зардал          | 17,315.0    | 15,030.7    | 2,284.3            | 86.8    |
| 3   | 80103 Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ | 760.0       | 760.0       | -                  | 100.0   |

**Баянхонгор аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

|   |                                      |             |             |          |       |
|---|--------------------------------------|-------------|-------------|----------|-------|
| 4 | 80220 Холбооны суваг ашигласны хөлс  | 840.1       | 840.0       | 0.1      | 100.0 |
| 5 | 80229 Шийдвэр гүйцэтгэлийн үйлчилгээ | 1,795.4     | 1,597.0     | 198.4    | 88.9  |
| 6 | 80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,  | 330.0       | 330.0       | -        | 100.0 |
|   | Нийт дүн                             | 1,788,290.9 | 1,713,682.1 | 74,608.8 | 95.8  |

*Эх сурвалж: Төсвийн гүйцэтгэлийн тайлангаас*

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үр дүнг нэгтгэв. Үүнд:

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн А/27 дугаар тушаалаар Баянхонгор аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт 2 шийдвэр гүйцэтгэгчийн албан тушаал батлагдсанаар нийт 37 алба хаагчтай болгож нэмэгдүүлсэн. Тайлант оны эцэст 3 орон тоо дутуу үйл ажиллагаа явуулсан бөгөөд энэ хугацаанд орон тооны цомхотгол хийгдээгүй байна.
2. Хоол, унааны хөнгөлөлтийг газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн Б/03 дугаар тушаалаар нэг өдөрт 13.0 мянга, унааны хөнгөлөлтийг 2.0 мянган төгрөгөөр тооцож тайлант онд 100,000.0 мянган төгрөгийн төсөв баталж 79,716.0 мянган төгрөгийн зарцуулсан байна.
3. Тайлант онд Аймгийн засаг даргын 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн А/153 дугаар захирамжаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын “Хангайн бүс”-ийн алба хаагчдын нэгдсэн сургалт зөвлөгөөнийг зохион байгуулсан байна. Аймгийн засаг даргын нөөц хөрөнгөнөөс 15,000.0 мянган төгрөгийн сургалт зөвлөгөөний зардлыг санхүүжүүлж зарцуулсан байна.

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар Аймгийн ЗДНХ-өөс Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын “Хангайн бүс”-ийн алба хаагчдын нэгдсэн сургалт, Аймгийн ИТХ-аас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд нийт 32,600.6 мянга, дээд шатны төсвийн захирагчаас 10,000.0 мянган төгрөг нийт 42,600.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж урсгал үйл ажиллагаанд 42,600.0 төгрөгийг зарцуулсан байна.

### **3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Баянхонгор аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь 2025 онд хоол хүнсний 44,100.0 мянга, шатахууны 21,800,0 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааг харьцуулалтын аргаар зарлаж зохион байгуулсан байна. Худалдан

авах ажиллагааны үр дүнд нийт 63,662.0 мянган төгрөгийн гэрээ байгуулж 2,237.1 мянган төгрөгийн тендерийн хэмнэлт гаргасан байна.

Мөн Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл 2,000.0 мянга, Багаж, техник хэрэгсэл 7,000.0 мянган төгрөгийн худалдан авалтыг шууд гэрээ байгуулсан байна.

#### **4. АУДИТЫН ТАЙЛАН**

##### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Даваадорж гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 2/21 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2025 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Баянхонгор аймгийн Баянхонгор аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дарга хурандаа Д.Батгэрэл 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийг хүртэл, даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч дэд хурандаа А.Энхтүвшин 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Н.Доржсүрэн нар зурж хөрөнгийг захиран зарцуулжээ.

##### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн гүйцэтгэлийн нийт зардлыг сонгож, материаллаг байдлын түвшин 1.0 хувиар тооцож материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны батлагдсан төсвийн нийт зардлын 1,786,556.1 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 17,136.8 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 11,138.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Тухайн байгууллага нь төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлж батлагдсан төсвийн хүрээн ажилласан байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 233,805.4 мянган төгрөгийн 23 гүйлгээг мэдээлэхээс 86,450.6 мянган төгрөгийн 7 гүйлгээ мэдээлээгүй байна.

Орлогын 1,884,737.0 мянган төгрөгийн 22 гүйлгээ мэдээлэхээс 42,600.0 мянган төгрөгийн 4 гүйлгээ мэдээлээгүй байна.

Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 62,881.9 мянган төгрөгийн 21 шийдвэрийг шилэн дансны цахим хуудсанд бүрэн байршуулж мэдээлсэн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Шилэн дансны цахим хуудсанд мэдээлээгүй 129,050.6 мянган төгрөгийн 11 гүйлгээг аудитын явцад шилэн дансны цахим хуудсанд нөхөн мэдээлүүлж залруулав.

#### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

#### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Тайлант хугацаанд завсрын аудит хийгдээгүй.

#### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг “Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар”-ын аудитор А.Адилзаяа гүйцэтгэж аудитаар зөрчил илрээгүй өөрчлөлтгүй санал дүгнэлт өгсөн байна

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

Аудитаар алдаа зөрчил илрээгүй тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгөх санал хүргүүллээ.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.